



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/666

Булгая сум

**Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан "Зураг төслийн жишиг үнийн дүрэм" БД81-16-20, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ний өдрийн XIX/08 дугаар хуралдааны "Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай" тогтоолын 4 дугаар хавсралтын 2.2 дахь хэсэг, Булган аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/651 тоот захирамжийн хавсралтын 21 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банк, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Дашинчилэн суманд гүйцэтгэж буй эрүүл мэндийн төвийн барилга, гадна инженерийн шугам сүлжээний ажлын трассыг 2023 онд Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн сумын төвийн авто замын ажилтай холбоотойгоор өөрчлөлтийн зураг төсвийн ажлыг 5,000,000 (таван сая) төгрөгөөр "Хатанбаатар" ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Хатанбаатар" ХХК-ийн захирал (М.Батбаяр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-г үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



5 дугаар Ажил 2024 өдөр бүр Дос/2024/Засахирамж

6324010943